

2016 ОНЫ ГАДААД АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ					
Байгууллагын нэр	Мэргэжилтний нэр /Тайлан бичсэн/	Албан тушаал	Холбоо барих утас	Facebook хаяг	Он сар өдөр
Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар	Х.Нарангэрэл	Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн	94839684	Narangerel Khashhuu	2016.12.05
НЭГ.ГАДААД ТОМИЛОЛТ					
Албан айлчлал, Сургалт, хурал, үзэсгэлэн, туршлага судлах аялал гэх мэт	Захирамж Шийдвэрийн хугацаа	Хамрагдсан хугацаа	Улс, хот	Зорилго, үр дүн	Зардлын эх үүсвэр
ХОЁР. ГЭРЭЭ, САНАМЖ БИЧИГ					
Хамтын ажиллагааны чиглэлээр байгуулсан санамж бичиг, гэрээ	Гэрээ, санамж бичиг байгуулсан албан тушаалтан	Он сар өдөр	Улс, хот	Зорилго	Биелэлт үр дүн
НҮБ-ын Хүүхдийн сан НЗД-тай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг хангуулж, тайлагнаж ажиллах	Нийслэлийн Засаг Дарга Э.Бат-үүл	2016 он			Санамж бичгийн дагуу 6 чиглэлээр хамтран ажиллалаа. /тайланг хавсаргав./
ГУРАВ. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА					
	Шийдвэрийн хугацаа	Улс, хот	Он сар өдөр	Зорилго	Биелэлт үр дүн
Харилцаат дүүрэг, хотуудтай хэрэгжүүлсэн уламжлалт арга хэмжээ					
Гадаад зочдыг хүлээн авсан					
Бусад арга хэмжээ					

2017 ОНЫ ГАДААД АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАХ САНАЛ

Д/д	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Хамтрах байгууллага	Хариуцах газар
	Олон улсын Хүүхдийн зуслантай туршлага судлах аялал	2017	Монголын зуслангуудын холбоо	
	Солонгосын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг мэргэжилтэн туршлага судлах, хүний нөөцийн солилцоо	2017	БНСУ-ын Сөүл Гвангянг	

ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА

Я.БАЙГАЛМАА

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ Э.БАТ-ҮҮЛ, НЭГДСЭН ҮНДЭСНИЙ
БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН САНТАЙ ХАМТАРСАН “ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ”-ЫН ХҮРЭЭНД
ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2016 оны 11 дүгээр сарын 20

Улаанбаатар хот

№	Хамтын ажиллагааны чиглэл	Хэрэгжилт	Үр дүн
1.	<p>“Хүүхдэд ээлтэй хотын санаачлага” үүнд хүүхдэд ээлтэй засаглал, бүтэц, төлөвлөлт, төсөвтэй холбоотой зарчмуудыг хөхүүлэн дэмжих, хэрэгжүүлэх. Хот сууринд хүүхдүүд нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүртэх болон хүүхэд бүрийн бүрэн дүүрэн хөгжиж төлөвших боломжийг хязгаарлаж буй ялгаатай байдлыг шийдвэрлэхийн тулд нотолгоонд суурилсан бодлого боловсруулах зорилтын хүрээнд</p>	<p>“Хүүхдэд ээлтэй Улаанбаатар” хөтөлбөрийг Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хурлаар 2015 оны 10 дугаар сарын 20-нд хэлэлцүүлж саналыг тусган 2015 оны 11 дүгээр сарын 20-ны 200 дугаар тогтоолоор Нийслэлийн Иргэдийн Тэргүүлэгчдийн Хурлаар хөтөлбөр батлагдсан. 2016 онд ХЭУБ хөтөлбөрийн хүрээнд дараах 8-н төслийг хэрэгжүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> ✓ <i>"Бид гэр бүлдээ хайртай,</i> ✓ <i>Хөгжлийн харандаа" форум,</i> ✓ <i>"Сэтгэлийн үндэс" тусч хөдөлгөөн,</i> ✓ <i>Хүүхдийн утас 108-ын хариу үйлчилгээг 152 хорооны Хамтарсан багаар үзүүлэх 108х152 төсөл,</i> ✓ <i>Зорилтот бүлгийн хүүхдийн эрхийг хангаж, хөгжлийг дэмжих "Сэтгэлийн гал" төсөл,</i> ✓ <i>Хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдэд итгэл урам зориг өгөх "Хүслийн захидал",</i> ✓ <i>Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх "Хайрын гар" авардс,</i> ✓ <i>Хүүхдэд чиглэсэн уран бүтээлийг дэмжих "Хүслийн галт тэрэг" интертайнмент төслүүд болно.</i> <p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 08 тоот тогтоолоор Гэр бүлийн өдрийг сар бүрийн 4 дэх долоо хоногийн “Ням” гарагт тэмдэглэн өнгөрүүлж байхаар тогтоол батлагдсан.</p>	<p>Хүүхдэд ээлтэй Улаанбаатар” хөтөлбөр батлагдаж 250 сая төгрөг 2016 оны төсөвт төсөвлөгдсөн.</p> <p>Хөтөлбөр 2016-оноос 2020 он хүртэлх хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжинэ.</p>

		<ul style="list-style-type: none"> ➤ Гэр бүлийн өдрийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, мэдээллийг 14 телевиз, 3 сайт, 2 сонин, 1 радио олон нийтэд нээлттэй хүргэсэн. ➤ Гэр бүлийн өдрийг олон нийтэд сурталчлах зорилгоор Гэр бүлийн өдрийн логог бий болгож Facebook хуудаснаа profile нүүр хуудас хийж, гэр бүлийн өдрийн шторк-1, Гэр бүлийн өдрийг тэмдэглэх арга зүйн мэдээлэл зөвлөгөө хүргэх зорилготой Хүүхэд-Гэр бүл page нээн хөтлөн ажиллуулж нийт 3481 хүнд хүрсэн байна. ➤ “Нийслэлийн шилдэг гэр бүл, шилдэг хүүхэд” шалгаруулах үйл ажиллагааг нийслэлийн 9 дүүргийн 132 хороонд зохион байгуулсан. Нийслэлийн 9 дүүргийн 129 хороонд Авьяаслаг гэр бүл, Спортлог гэр бүл, Бүтээлч гэр бүл, Оюунлаг гэр бүл, Хүмүүнлэг гэр бүл гэсэн 5 номинацаар 645 шилдэг гэр бүл, 258 шилдэг хүүхэд шалгарч шагнал урамшуулал хүртсэн. 	
2.	<p>Хүүхдийн хөгжлийн асуудлаар болон хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, тхайлбал захын дүүргийн хүүхдүүдийн эрүүл мэнд, боловсрол, сургуулийн өмнөх боловсрол, зугуйлан болон сургалт, ус ариун цэврийн байгууламж үэрэг нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд</p>	<p>“Хүүхдэд ээлтэй хот”-ын үнэлгээг орчны 12, гэр бүлийн 4, үйлчилгээний 7, оролцооны 2 нийт 25 үзүүлэлтээр Нийслэлийн 152 хороо 1212 хэсгийн 12189 хүүхдүүдээс авч нэгтгэсэн.</p> <p>НИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/119 тоот захирамжаар Нийслэлийн алслагдсан гэр хорооллын хүүхдүүдийг хөгжүүлэх, авъяасыг нээн хөгжүүлэх зорилгоор захын гэр хороололд “Хүүхдийн ордны салбар дугуйлангууд”-ыг нээн хичээллүүлж эхэлсэн. 2015 оны байдлаар 4 дүүргийн 5 хороонд 7 төрлийн 19 дугуйланд нийт 1660 орчим хүүхэд хамрагдан суралцсан.</p>	
3.	<p>Хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийлэл, даармт мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн тохиолдолд хариу үйлчилгээ үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх, тухайлбал насанд хүрээгүй хүүхдийн гэмт хэрэг, хүүхэд ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хүүхдийн хөдөлмөр, замын хөдөлгөөний аюулгүй байдал, бэлгийн мөлжлөг хүүхэд худалдаалах зэрэгт холбоотой арга хэмжээ хүүхэд</p>	<ul style="list-style-type: none"> • Хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх үйлчилгээний нэгжийг Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборт бий болгосон. • Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн газраас санаачлан Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэмжлэгтэйгээр гэмт хэрэгт холбогдох магадлалтай, эрсдэлт бүлгийн хүүхдүүдийг нийгэмшүүлэх зорилгоор “МӨРӨӨДЛИЙН ХӨЛБӨМБӨГ” төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд тус газрын мэдээллийн сан болох 	

	<p>хамгааллын үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд</p>	<p>Эрсдэлийн түвшин тогтоох програмд бүртгэлтэй Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн 30 хүүхдийг сонгон авч төсөлд хамруулсан.</p> <p>Төслийн эхэнд төсөлд хамрагдах хүүхдүүдийн нөхцөл байдлыг үнэлж хүүхэд бүртэй ажилласан. Төслийн хүрээнд хөлбөмбөгийн болон хүүхдийн төлөвшилд зориулсан вакум сургалтуудыг зохион байгуулсан. Хүүхдүүдэд хөлбөмбөгийн онолын болон бэлтгэл сургуулилтыг төрөлжсөн байдлаар Олон улсын Мөрөөдөл хүүхдийн зусланд зохион байгуулсан. Төслийн багуудын хооронд нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулж шигшээ багийг бүрдүүлэн 11 дүгээр сард эхлэх Дуулиан 2020 тэмцээнд оролцуулах багийг бүрдүүлж цаашид бэлтгэл сургуулилтыг хийж байна.</p>	
<p>4.</p>	<p>Агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах, хүүхдэд үзүүлж буй агаарын бохирдлыг үр нөлөөг багасгах стратеги боловсруулах зорилтын хүрээнд</p>	<p>-</p>	<p>-</p>
<p>5.</p>	<p>Нийслэл хотын хүүхэд багачуудын аж байдалд дүн шинжилгээ хийх, хамтын ажиллагааны ахиц дэвшлийг үнэлэх, хамтын ажиллагааны шинэ чиглэлүүдийг харилцан зөвшилцсөний үндсэн дээр тодорхойлох зорилтын хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> • Хамгаалал шаардлагатай байгаа хүүхдийн “Эрсдлийн түвшинг тогтоох програм”-д Нийслэлийн 9 дүүргийн 152 хорооны зорилтот 7 бүлгийн нийт 3075 хүүхдийн мэдээллийг шивж оруулан мэдээллийн сан буюу серверийг үүсгэж мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. • Эрсдлийн түвшин тогтоох програмын 4 бүлгийн хүүхдэд 2016 оны 11 сарын байдлаар дүн шинжилгээ хийж ажилласан. Хараа хяналтгүй 184, Хөдөлмөр эрхэлдэг 173, Хүчирхийлэлд өртсөн 153, гэмт хэрэгт холбогдсон 53 хүүхэд байна. Үүнээс өндөр эрсдэлтэй 43 хүүхэд байна Эдгээр хүүхдийн мэдээллийг гаргаж 9 дүүргийн Хүүхэд,гэр бүлийн хөгжлийн төвүүдэд хүргүүлэн үйлчилгээ үзүүлсэн. • Хөгжлийн харандаа аппликэйшн хийх ажлын хүрээнд www.manaikhoroo.mn цахим хуудсанд хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын 2 бүлгийн Тусгай сургууль, Гэр бүлд зөвлөгөө өгөх төв, Цахим тоглоомын газар, Усан спортын сургалтын төв, Шашин,сүм хийдийн газар, Үзвэр үйлчилгээний төв, Асрамж, халамжийн байгууллага, Спортын талбай, 	<p>Хамгаалал шаардлагатай байгаа хүүхдийн “Эрсдлийн түвшинг тогтоох програм”-ын мэдээллийн сан үүссэн.</p>

		<p>цогцолбор, чийрэгжилтийн газар, Хүүхэд харах үйлчилгээний төв, Өдөр өнжүүлэх төв, Хүүхдийн зуслан, Дугуйлан, секц, Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд, Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв, Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ОУ-ын байгууллага, Зорилтот бүлгийн хүүхдийн 16 төрлийн 200 гаруй байгууллагын мэдээ мэдээлэл, байршлыг оруулсан.</p>	
6.	<p>Хүүхдийн эрхийн асуудлаар Улаанбаатар хотын иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны хамтарсан үйл ажиллагаа хэрэгжүүлэх зорилтын хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн эрхийн тухай хуулийг олон нийтэд сургалчилах зорилгоор 5 төрлийн богино хэмжээний сурталчилгааны бичлэгийг боловсруулан фэйсбүүк хуудсанд байршуулсан. <ul style="list-style-type: none"> • Хүүхдийн эрхийн тухай хууль бичлэг 1525 хүнд хүрч 317 хүн үзсэн • Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх бичлэг 1426 хүнд хүрч 227 хүн үзсэн • Хүүхдийн хөгжих эрх бичлэг 1168 хүнд хүрч 172 хүн үзсэн • Хүүхдийн хамгаалуулах эрх бичлэг 1711 хүнд хүрч, 377 хүн үзсэн • Хүүхдийн оролцох эрх бичлэг 1921 хүнд хүрч, 283 хүн үзсэн, нийт 7751 хүнд хүрч 1376 үзсэн. • Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн газрын хүүхэд гэр бүлд зориулсан албан ёсны хуудас болох Хүүхэд гэр бүл фэйсбүүк хуудсыг 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлүүлэн хөтөлсөн. Энэ хугацаанд 420 хүүхэд гэр бүлд зориулсан мэдээ мэдээллийг байршуулж 371,855 хүнд хүргэж, 3830 хүнд хуудас таалагдсан байна. 	

